

Үйл ажиллагааны стратегийн зорилго, тэргүүлэх чиглэлийн хүрээнд дэвшүүлсэн 2023 оны үндсэн зорилт хүрээнд гарах үр дагавар

Монголын төмөр зам ТӨХК нь 2023 оны зорилтоо тодорхойлохдоо 2023 оныг бүрэн цахимжсан, бүтээмжийг дээдэлж, хариуцлага үр дүнг тооцох жил болгон зарласан салбарын яам буюу ЗТХЯ -ны зорилтод нийцүүлэн дараах үндсэн долоон зорилтыг дэвшүүлэн ажиллахаар төлөвлөж байна:

1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ. Ачаа тээврийг 3,5 сая тонн хүргэнэ.
2. Төмөр замын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ. Тавантолгой - Зүүнбаян чиглэлийн төмөр замыг байнгын ашиглалтад оруулж, баруун, зүүн босоо төмөр замын барилгын ажлыг эхлүүлж, төслийн хил холболтын төмөр замуудыг барина.
3. Төмөр замчдыг бэлтгэж, ур чадварыг дээшлүүлнэ. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулна.
4. Экспортыг нэмэгдүүлж, ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагааг өргөжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Олон Улсын менежментийн стандартуудыг нэвтрүүлнэ.
5. Засаглал, нийгмийн үр нөлөөг сайжруулах компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлнэ.
6. Эдийн засаг, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулна.
7. Авлигын эсрэг хууль тогтоомж, арга хэмжээ хэрэгжүүлнэ.